



**Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс
авсан 2025 оны 03 дугаар сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний тасагт иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 65 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 29 иргэн буюу 44,6% эмэгтэй, 36 иргэн буюу 55,4 % нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-хүртэл 1 иргэн буюу 1,5%, 20-29 насны 2 иргэн буюу 3,1% , 30-39 насны 9 иргэн буюу 13,8%, 40-49 насны 15 иргэн буюу 23,1% , 50-59 насны 21 иргэн буюу 32,3%, 60-аас дээш 17 иргэн буюу 26,2% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 65 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 23 иргэн буюу 35,4%, тэтгэмж 9 иргэн буюу 13,8%, сайн дурын даатгал 9 иргэн буюу 13,8%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 8 иргэн буюу 12,3%, бусад үйлчилгээ 5 иргэн буюу 7,7%, зөвлөгөө мэдээлэл 11 иргэн буюу 16,9% тус бүр байна.


Зураг3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 37 даатгуулагч буюу 56,9%,-н маш сайн үнэлгээг өгсөн, сайн үнэлгээг 25 даатгуулагч буюу 38,5%, дунд үнэлгээг 2 даатгуулагч буюу 3,1%, 1 даатгуулагч муу буюу 1,5%, муу маш муу үнэлгээг өгөөгүй байна.




Зураг4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 65 иргэнээс “Тийм” гэсэн үнэлгээг 63 иргэн буюу 96,9% “Үгүй” үнэлгээг 2 иргэн буюу 3,1% өгсөн байна.

Зураг5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 64 иргэн буюу (98,5%) сэтгэл ханамжгүй 1 иргэн (1,5%) тус бүр өгсөн байна.



Зураг6:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа..\

Мэдээлэл ил тод байдаг уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 65 иргэдийн Тийм үнэлгээг 42 иргэн буюу (64,6%), Үгүй үнэлгээг 3 иргэн буюу (4,6%), Мэдэхгүй үнэлгээг 20 иргэн буюу (30,8%) тус бүр үнэлсэн байна.

Зураг7: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?





Дүгнэлт: Судалгаанд оролцсон 65 иргэдийн “Тийм” үнэлгээг 5 иргэн буюу 7,7%, “Үгүй” үнэлгээг 60 иргэн буюу 92,3% тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна.

Зураг8: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас “Тийм” үнэлгээг 4 иргэн буюу 6,2%, “Үгүй” үнэлгээг 61 иргэн буюу 93,8% тус бүр үнэлсэн байна.

Судалгааны нэгтгэл хийсэн:

Ахлах төлөөлөгч: /Н.Шүрэн-Эрдэнэ/